

German-Mongolian
Business Association

DMUV

Герман-Монголын Бизнес
Эрхлэгчдийн Холбоо

Nomadic spirit meets Made in Germany

Баталсан огноо: 2023 оны 06-р сарын 08

GERMAN MONGOLYN БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБООНЫ ДҮРЭМ

I ҮНДСЭН ЗАРЧИМ

Зүйл 1 Ерөнхий заалт

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭХИЙН АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨН ХОМИ ТААЗАР
УЛСЫН БҮРТГЭГЧ УСР

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн
дугаар 9072002116

2023 оны 08 сарын 09 өдөр

Бүртгэсэн: Улсын (ахлах) бүртгэгч
сарын үсэг

1. Герман Монголын Бизнес Эрхлэгчдийн Холбоо (цаашид холбоо гэх) нь Монгол Улсын хуулийн дагуу бүртгүүлсэн төрийн бус байгууллага (ТББ) байна. Холбоо нь Германы Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаар (DINК гэх) хүлээн зөвшөөрөгдөж улмаар хоёр тал хүлээн зөвшөөрсөн Германы Худалдаа аж үйлдвэрийн танхимын гадаад орнууд дахь төлөөлөгчийн газар болох зорилготой ажиллана.
2. Холбооны нэр:
 - монголоор: Герман Монголын Бизнес Эрхлэгчдийн Холбоо товч нэр: ГМБЭХ
 - германаар: Deutsch-Mongolischer Unternehmensverband Холбоо товч нэр: DMUV
 - Холбооны хаяг: UBH Center, 13-р давхар, 1304 тоот, Энхтайваны өргөн чөлөө-23, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14210, Монгол Улс
3. Холбооны хэл нь монгол, герман хэл байна.
4. Холбоо нь удирдах зөвлөлөөс баталсан гарын үсгүүд болон нэг тамгатай байна. Тэдгээрийг төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.
5. 2-р зүйлд заасан зорилго, ажил үүргүүдийг хэрэгжүүлэхийн тулд холбоо нь

Герман-Монголын Бизнес Эрхлэгчдийн Холбоо

UBH Center, 13 давхар, 1304 тоот,
Энхтайваны өргөн чөлөө-23,
1-р хороо, Сүхбаатар дүүрэг


Гүйцэтгэх Захирал
Др. Магнус Мюллер

Улсын бүртгэлийн Гэрчилгээ
Улсын бүртгэлийн № 9072002116
Регистрийн № 1014765

Улаанбаатар
Монгол улс

Утас: +976 7011 6011
И-мэйл: info@dmuv.mn





German-Mongolian
Business Association

DMUV

Герман-Монголын Бизнес
Эрхлэгчдийн Холбоо

Nomadic spirit meets Made in Germany


гишүүдийн хурлын тогтоол дээр үндэслэн салбар, нэгж болон төлөөлөгчийн газар мөн салбар нийгэмлэг байгуулж болно.

6. Холбооны бүтэц нь бүх гишүүдийн хурал, удирдах зөвлөл, ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүн/ гүйцэтгэх захирал болон санхүүгийн хянагч нараас тогтоно.

Зүйл 2

Зорилго, гүйцэтгэх ажил үүрэг

1. Холбоо нь дараах ажил үүрэгтэй:
 - а Гишүүдийн ашиг сонирхлыг төлөөлөх
 - б ХБНГУ болон Монгол улсын хоорондох худалдаа эдийн засгийн харилцааг дэмжих
 - с Монгол дахь Германы эдийн засаг болон ХБНГУ дахь Монголын эдийн засгийн сонирхолд нийцүүлэн ажиллах. Үүнд мэдээлэл солилцох, бизнесийн үйлчилгээ, зөвлөгөө өгөх, эрх ашгийг төлөөлөх зэрэг үйл ажиллагаанууд багтана.
2. 1-т заасан зорилгуудад хүрэхийн тулд холбоо нь хуульд өөрөөр заагаагүй бол дараах ажил үүргийг гүйцэтгэнэ:
 - а Мэдээлэл, зөвлөгөө өгөх, нэн ялангуяа санал дүгнэлт гаргах, зах зээлийн судалгаа болон тойм мэдээлэл гаргах
 - б Хоёр улсын компаниудын хоорондын бизнесийн харилцаа холбоог хөгжүүлэх, дэмжих, зуучлах
 - ц Хоёр улсын эдийн засгийн хүрээнүүдийн хооронд холбоо тогтоох, тэдгээрийг дэмжих
 - д Хоёр улсын засгийн газруудын болон төрийн байгууллага, бизнес эрхлэгчдийн хооронд харилцаа холбоо тогтоох, дэмжиж хөгжүүлэх



German-Mongolian
Business Association

DMUV

Герман-Монголын Бизнес
Эрхлэгчдийн Холбоо

Nomadic spirit meets Made in Germany

- э Герман болон Монголын эдийн засгийн төлөв байдлын талаар, түүнчлэн эдгээр улсууд дахь эдийн засаг, худалдааны бодлогын асуудлын хөгжил, явцын тухай мэдээллүүдийг цуглуулах, түгээх. Жишээ нь: нийтэд тараах бичиг;жилийн тайлан, илтгэх хуудас болон бусад нийтлэл
- ф Хэвлэлийн хурал, мэдээллийн семинар, санал солилцох уулзалт зэргийг зохион байгуулах түүнчлэн дүрэмд заасан зорилгод нийцсэн тохиолдолд ийм төрлийн арга хэмжээнд оролцох
- г Хоёр улс дахь худалдаа, ханган нийлүүлэлт ба хөрөнгө оруулалтын боломжуудыг судлан тогтоох
- х 1-т заасан зорилгод чиглэсэн хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагааг эрхлэх
3. Холбоо нь үйл ажиллагаагаа ХБНГУ-ын Холбооны Эдийн засгийн хамтын Ажиллагаа Хөгжлийн яам (BMZ гэх), Холбооны Эдийн засаг Эрчим хүчний яам (BMW гэх) болон хоёр улсын бусад ач холбогдол бүхий институт, албан байгууллагатай нягт хамтран ажиллах.
4. Холбоо нь тусгай хууль тогтоомжид тусгасан улс төрийн нам, хөдөлгөөн, үзэл суртлын аливаа үйл ажиллагаанаас хол байна.

Зүйл 3

Санхүү, эд хөрөнгө

1. Холбооны үйл ажиллагаа, үйлчилгээ нь ашгийн төлөө бус байна. Холбооны үйл ажиллагааны орлого дүрэмд заасны дагуу холбооны зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд зарцуулагдана. Холбооны санхүү, эд хөрөнгө зөвхөн дүрэмд заасан үйл ажиллагаа, ажил үүрэгт хэрэглэгдэнэ. Тэдгээрийг эдийн засгийн зарчмийн дагуу хэмнэлттэйгээр зарцуулна.
2. Холбоо нь гишүүн болон гишүүн буст үйлчилнэ. Гишүүдийг тусгай

